

**“НОМИН ХИШИГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны ~~07~~-р сарын ~~27~~ өдөр

№

Баянхонгор сум

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2020 оны 7-р сарын 27-ны өдөр 10.00 цагт Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Номинхишиг ХК-ийн байранд хуралдаж, хурлын дарга Ш.Батжаргал удирдав.

Хуралд оролцсон хүмүүс :

ТУЗ-ын дарга: 1. А.Номинхиш ТУЗ-ын гишүүн: 2. Оюунболд

ТУЗ-ын гишүүн: 3. Д.Цэрэнням

ТУЗ-ын гишүүн: 4. Ж.сангижав

ТУЗ-ын хараат бус гишүүнээр нэр дэвшигч: Л.Гантуяа

Хувьцаа эзэмшигчид:

- | | |
|---------------|--|
| 1. Б.Адясүрэн | 16,889 ширхэг хувьцааны |
| 2. Б.Оюутболд | 18,982 ширхэг хувьцааны саналын эхтэй оролцов. |

Хурлын тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж, компанийн нийт гаргасан 57,000 хувьцаанаас саналын эрхтэй хувьцааны тоог 35,871 ширхэг хувьцаагаар тогтоож, хурлын ирц 62,9 хувьтай байгааг мэдээлж, компанийн тухай хуулийн 69.1 заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлж болохыг хурлын даргад зөвшөөрөв.

Хурал 10 цаг 00 минутанд эхлэв.

Хурлыг дарга Ш.Батжаргал хурлыг нээж, хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

Хурлын дэг:

1. Хурлын ирцийг бүртгэх. /тоологын комисс/ 09.30-10.00 цаг
2. Хурлын ирцийг мэдээлэх. /тоологын комисс/ 10.00 цаг
3. Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах.
/хурлын дарга/
4. Хурлаар хэлэлцэх асуудалыг дараалалын дагуу уншиж танилцуулах. Үүнд:
5. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан бизнес төлөвлөгөө
 - Компанийн санхүүгийн тайлан
 - Компанийн 2020 оны бизнес үйл ажиллагааны тайлан
 - Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулах
6. Асуулт хариулт, санал шүүмжлэл тавих. / нэг хүн үг хэлэх хугацаа 10 минут/
7. Хурлын завсарлага
8. Санал хураалтын дүнг хуралд оролд оролцогчдод танилцуулах. /тоологын комисс/
9. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах / хурлын дарга/
10. Хурлыг хаах. / хурлын дарга/

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

Компанийн ГЗ-ийн 2021 оны 6-р сарын 16-ны 20/15 тоот тогтоолын дагуу тус ээлжит бус хурлаар лдараах асуудлуудыг хэлэлцэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

1. Компанийн санхүүгийн тайлан
2. Компанийн үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөө

Хурлын дарга Ш.Батжаргал хурлаар хэлэлцэх асуудлуудыг дэс дараалалын дагуу уншиж танилцуулав.

Гүйцэтгэх захирал Ж. Сангизав: компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан. 2021 оны бизнес төлөвлөгөөний талаар уншиж, танилцуулав. /тайлан хурлын материалд/

Асуулт, хариулт:

Л. Гантуяа: - Компани ногдол ашиг өгч чадахгүй байгаад тайлбар өгнө үү.

Гүйцтгэх захирал Ж. Сангизав – Манай компани сүүлийн 2 жил үйл ажиллагаа явуулахгүй учраас ногдол ашиг хувиарлаж, чадахгүй байна.

Л. Гантуяа: - Компани тоног төхөөрөмжд шинэчлэгдсэн үү.

Гүйцтгэх захирал Ж. Сангизав: - сүүлийн жилүүдэд бидний үйл ажиллагаа covid-19 улмаас санхүүгийн байдал доголдож, ажил хийж чадаагүй. 2021 онд улс болон аймгийн тендерт идэхтэй оролцон борлуулалтын орлого болон ашгийн хэмжээг нэмэгдүүлсэн, компанийн техник тоног төхөөрөмжийг шинчлэлт хийхээр төлөвлөж байгаа.

Ш.Батжаргал: - Хувьцаа эзэмшигчидээ өөр асуух зүйл байна уу? Байхгүй бол саналаа өгөөд түр завсарлана уу.

Асуулт хариултын цаг дуусч тоологын комисст саналын хуудасаа өгөөд хувьцаа эзэмшигчид түр завсарлав.

Тооллгын комисс саналын хуудасны дүнг нэгтгэн танилцуулав.

Ш.Батжаргал: - Нийт 57,000 ширхэг хувьцааны саналын эрхтэй 171 хувьцаа эзэмшигч хуралд оролцохоос биечлэн ирсэн 2 хувьцаа эзэмшигч саналаа өгч, нийт дүнгээр 2 хувьцаа эзэмшигчийн саналыг нэгтгэллээ.

Үүнд:

Санхүүгийн тайлан	зөвшөөрсөн 62,9 хувь, татгалзсан 0 хувь
Үйл ажиллагааны тайлан	зөвшөөрсөн 62,9 хувь, татгалзсан 0 хувь
Бизнес төлөвлөгөө	зөвшөөрсөн 62,9 хувь, татгалзсан 0 хувь

- Ердийн нэр дэвшигч дэвшүүлэх
- Хараат бус гишүүд дэвшүүлэх

Хурлын дарга Ш.Батжаргал ХЭЭБ хурлаас гэрсан ХЭЭБХ-ийн тогтоолуудыг уншиж танилцууллаа.

**“НОМИН ХИШИГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ШИЙДВЭР:**

2021 оны 07-р сарын 27 өдөр

Баянхонгор сум

Шийдвэрлэсэн нь:

1. Компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг холбогдох цахим хуудсанд тогтмол байршуулж байлгах. Цаашид компанийн үйл ажиллагааг сайжруулах боломжит бүх арга хэмжээг авч ажиллахыг гүйцэтгэх захирал /Ж. Сангизав/-т даалгасугай
3. Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг баталсугай.
4. Компанийн дэргэдэх цалин урамшуулал, Аудит, нэр дэвших хороодыг ТУЗ-ийн хурлаар баталахаар шийдвэрлэв.
5. Хурлын дарга хурлыг хааж, үг хэлсэнээр Хурал 12.00 цагт өндөрлөв

Хурал удирдсан:

Хурлын дарга *Ш.Батжаргал* /Ш.Батжаргал/